



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 8/25

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Пүрэвжал овогтой Баттулгын Эрдэнэчандмань 1 дүгээр багийн Түлэнхий нэртэй газарт байрлах өвөлжөө, хаваржааны зориулалттай 2304012558 нэгж талбарын дугаар бүхий 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Баттулга овогтой Бат-Эрдэнэд шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны А/101 тоот захирамжийн П.Баттулгад холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА



П.ОТГОНБАЯР

230425092